



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2025 оны 08 сарын 21 өдөр

Дугаар А/297

Улаанбаатар хот

2025 оны төсвийн хуваарийг
шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн 36 дугаар жагсаалт, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан эрүүл мэндийн байгууллагын төсвийн удирдлагын бүрэн эрхийг хэрэгжүүлэх, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор эрүүл мэндийн байгууллагуудын 2025 оны төсвийн хуваарийг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих зардлын төлбөрийг гүйцэтгэлд үндэслэн холбогдох хууль тогтоомжийн дагуу санхүүжүүлэхийг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар /С.Энхболд/-т, төсвийн зарцуулах эрхийг нээж, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Санхүү, эдийн засгийн бодлогын газар /Э.Мөнхсүх/-т тус тус зөвшөөрсүгэй.

3. Батлагдсан төсвийг зохих журмын дагуу зарцуулж, байгууллагын хэвийн үйл ажиллагааг ханган ажиллахыг эрүүл мэндийн байгууллагуудын захирал, дарга нарт даалгасугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Д.Очирбат/-д даалгасугай.

САЙД



Ж.ЧИНБҮРЭН

141251339

